



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-7</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-25</i>

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	8-9
2. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	9-15
3. Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах	15-16
4. “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	16-24
5. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох	24-25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 50.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Ж.Баясгалан, О.Саранчулуун, А.Ундраа, С.Цэнгүүн;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Х.Булгантуяа, Д.Ганмаа, Т.Мөнхсайхан, М.Нарантуяа-Нара, Г.Хосбаяр, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Батлут, Ж.Баярмаа, Ш.Бямбасүрэн, Л.Гантөмөр, Ч.Номин, Ж.Чинбүрэн, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Э.Бат-Амгалан, О.Батнайрамдал, Х.Баттулга, Э.Болормаа, Д.Бум-Очир, С.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, С.Лүндэг, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Д.Цогтбаатар, Да.Цогтбаатар;

Хоцорсон: Н.Алтаншагай-53 минут, Ч.Анар-25 минут, Ц.Баатархүү-07 минут, Б.Батбаатар-16 минут, Д.Батбаяр-18 минут, Н.Батсүмбэрэл-12 минут, Б.Батцэцэг-07 минут, Б.Баярбаатар-05 минут, Ж.Галбадрах-06 минут, Г.Ганбаатар-09 минут, Д.Ганбат-44 минут, П.Ганзориг-06 минут, Х.Ганхуяг-03 минут, Ц.Даваасүрэн-23 минут, Т.Доржханд-09 минут, Б.Жавхлан-08 минут, Б.Жаргалан-02 минут, Ч.Лодойсамбуу-16 минут, Г.Лувсанжамц-02 минут, Ц.Мөнхбат-33 минут, Н.Наранбаатар-1 цаг 13 минут, О.Номинчимэг-45 минут, Г.Очирбат-04 минут, Б.Пунсалмаа-02 минут, Ц.Туваан-1 цаг 10 минут, Б.Түвшин-13 минут, С.Эрдэнэбат-18 минут.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны саналаар “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 58

Бүгд: 68

14.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн болон бусад Байнгын хороодод шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал З.Батырбек, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Уул уурхайн технологийн газрын дарга Ч.Алтанбагана нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Жаргалан, С.Эрдэнэбат нар үг хэлэв.

“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу хураалгасан санал:

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооноос гаргасан, Төслийн 5 дахь заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Татгалзсан: 30
Бүгд: 85
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулав.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 22
Бүгд: 86
74.4 хувийн саналаар буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 21
Бүгд: 86
75.6 хувийн саналаар буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 31
Бүгд: 86
64.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 29
Бүгд: 86
66.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулж дууслаа.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Жаргалан, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Боловсролын сайд П.Наранбаяр нар хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 57
Бүгд: 90
36.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 11 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ баталсан хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн

найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:21/

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:23/

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:23/

4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:24/

5.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./11:24/

6.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./11:24/

7.Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:25/

8.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:25/

9.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./11:25/

Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт

Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, 126 гишүүнээс 91 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд ирц 50,8 хувьтай болсон тул Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганых 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 5 асуудал байна.

1 дүгээрт “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

2-т Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

3-д хуулийн төслүүдийг эцэслэн батална.

4-д “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

5 дугаарт Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

1 дүгээр асуудал. Хэлэлцэх асуудалд оръё.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлэн явуулъя.

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлсэн байгаа.

Одоо Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Томьёоллоо уншина. Байж байгаарай. Бэлэн бус гишүүд гэдэг дээр нэлээн гишүүд гарч байна шүү. 36 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. 32 гишүүн санал хураалтад бэлэн болоогүй байна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт явуулъя.

“Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал

хураалт. Санал хураалтад 68 гишүүн оролцсоноос 10 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Өөрөөр хэлбэл 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдлаа. Үндсэндээ хэлэлцэх эсэхийг дэмжлээ. Болохгүй бол энэ чинь Үндсэн хууль зөрчсөн хэрэгт орох юм уу.

Ингээд “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүд олонх нь дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүллээ.

10.15 цаг.

2 дахь асуудалдаа оръё.

Монгол Улсыг 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Үүрийнтуяа Таныг индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 11 сарын 12-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 5 дахь заалтыг өөрчлөн найруулж, Тавантолгойн бүлэг орцтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн, төрийн нууцад авсан гэрээ хэлцлийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг авч, Улсын Их Хуралд тайлагнах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг холбогдох хууль, тогтоолын төсөлд нэмж тусган агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хууль, тогтоолын төслүүд болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хувилбарын төсөл эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгт энэ. Ажлын хэсэг мөн үү. Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Эмгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Гончигсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лувсанванданы Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Маамбын Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Зулпайн Батырбек Нийслэлийн өмчит “Улаанбаатар түншлэл төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Монхоогийн Амгаланбаатар “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Чойжамцын Алтанбагана “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Уул уурхай технологийн газрын дарга.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт явуулна. Ингээд намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүдээс ирүүлсэн нэрсийг өгч байна. 5 гишүүн нэрсээ өгсөн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Өглөөний мэнд хүргэе. Төсөв дагасан хууль тогтоомжуудыг яг орж ирсэн хувилбараар нь бол дэмжихгүй байсан. Улсын Их Хурал дахь ажлын хэсэг сайн ажилласан байна. Нэн ялангуяа Үндэсний баялгийн сантай холбоотой дагаж гарах хууль тогтоомжтой бол Засгийн газар яг өөртөө тусгайлсан эрх авч байгаад оффтейк гэрээ байгуулах гэж байсныг бас тодорхой хэмжээнд өөрчилсөн байна. Үүн дээр бол бас ажлын хэсэг сайн ажилласан байна гэж дүгнэхээр байна.

Үндсэндээ бол урт хугацааны гэрээ байгуулна. Биржийн үнээр борлуулахгүй. Өөрсдөө Засгийн газар энэхүү гэрээг байгуулна гэж оруулж ирсэн энэ санаархал нь бол өөрөө байж боломгүй асуудал. Ийм учраас ажлын хэсгийн хүрээнд үүнийгээ нээлттэй, ил тод, хуулийн дагуу зохион байгуул гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгааг бол сайшааж байна.

Цаашлаад Тавантолгойн бүлэг ордтой холбоотой урьд өмнө байгуулсан гэрээ, төрийн нууцад авсан гэрээ хэлцэл, хэн, яаж зөвшөөрсөн юм, хэн яаж төрийн нууцад авсан юм. Бүхий л энэ асуудлуудаа 2026 оны 3 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд тайлагнах үүрэг даалгаврыг бас өгч байгаа юм байна. Тэгэхээр хэрэвзээ энэ өгч байгаа үүрэг даалгаврыг биелүүлэхгүй бол яах вэ гэдгийг бас тодорхой болгомоор байна.

Үндсэндээ бол нэгнийгээ харлуулах, үл мэдэгдэх асуудлуудыг урьд өмнө нь Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүнээр хүртэл дамжуулан олон нийтэд хачирхалтай мэдэгдлүүдийг хийсэн. Тэгээд эцэстээ бол үнэнд гүйцэгдэж, нэг талын санаачилгаар цуцлах боломжгүй. Энэ бол олон улстай, 2 улсын хооронд байгуулсан хэлэлцээр гэж зарим асуудлуудыг хааж байна лээ. Үүнтэй нэгэн адилаар жоохон мэргэшсэн, хэлсэн үгэндээ Монгол Улсын хувьд хүрдэг, хийсэн ажлаа үгүйсгэдэггүй, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ улс төржүүлдэггүй ийм нөхцөл байдлыг бол хүсэж байна.

НӨАТ-ын буцаан олголттой холбоотой иргэдэд бас таатай юм шиг мэдээ дуулгасан боловч хэрэгжүүлэх хугацаагаа бол 10 сарын 1 хүртэл хойшлууллаа.

Үндсэндээ батлагдсан төсөв бол өөрөө бас нэлээд хүндрэлийг авчрах, хэрэгжүүлэхэд их хүнд төсөв батлагдсан учраас тун удахгүй бас төсвийн тодотгол орж ирнэ байх гэдэгт бол итгэлтэй байна. Эмч нартайгаа байгуулсан хэлэлцээрийн биелүүлэх төсөв нь бол батлагдаагүй. Өчигдөр хэлэлцээр эцэслэгдсэн байсан. Тэгэхээр энэ агуулгаараа бол Засгийн газар бас төсвийн тодотголоо одоогоос эхэлж бэлдэх нь зүйтэй гэдэг ийм санал, үг хэлж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Санал хэллээ. Амгаланбаатарын. Ганбаатар.

А.Ганбаатар: Энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа тухай дээр 1 асуулт байгаа юм.

5.1.13-д заасан “төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран ТЭЗҮ шаардагдахгүй бөгөөд мөнгөний үнэ цэний шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг орлуулж хийж болно.” гэсэн ийм санаатай заалт орсон байна лээ. Тэгэхээр миний асуух гэж байгаа асуулт нь болохоор нэмэлт, өөрчлөлтөд оруулж байгаа энэ заалт бол хууль зүйн үр дагавар гаргах юм биш үү.

Хэдийгээр төслөөс хамаарч ТЭЗҮ шаардагдахгүй гэж байгаа боловч төр, хувийн хэвшлийн хоорондох эдийн засгийн тооцоолол, үүнээс үр дагавар гарч, төсөлд доголдол гарвал яах юм бэ. Маш товчхондоо ТЭЗҮ-г орлуулах тооцоо, эдийн засгийн судалгаа, шинжилгээ гэж байдаг юм уу. Эндээс яагаад тодорхой төсөлд ТЭЗҮ шаардагдахгүй гэж байгаа юм бэ. Энийг тайлбарлаж өгөөч ээ гэж асууж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ. 3 номерын микрофон.

Т.Баясгалан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Баясгалан байна. Таны асууж байгаа энэ хуульд нэмэлтээр орж байгаа 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг таныг асууж байна уу гэж ойлголоо. Энэ 5.1.13-д заасан төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран ТЭЗҮ шаардахгүй байж болох ийм зохицуулалтыг нэмэлтээр оруулж байгаа. Гэхдээ энэ нь бол нийтийн зориулалттай төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж байгаа төслүүдийг 2 бүлэгт бол хувааж авч үздэг.

1 дүгээрт нь бол төрийн нийтийн зориулалттай дэд бүтэц;

2 дугаарт нь төрийн үйлчилгээний төсөл гээд.

Тэгэхээр нийтийн зориулалттай дэд бүтцийн төслүүд дээр бол бүгд дээр нь бол ТЭЗҮ бол шаарддаг энэ зохицуулалт нь бол хэвээрээ байх юм. Харин төрийн үйлчилгээний буюу яг түншлэлээр хэрэгжүүлэх зарим төрийн үйлчилгээний төслүүд дээр бол заавал ТЭЗҮ шаардах нь өөрөө бас хувийн хэвшлийн түншлэгчид бол дарамт ямар нэгэн байдлаар бас ТЭЗҮ шаардах процессыг сунжруулах, удаашруулах ийм нөхцөл байдлыг үүсгээд байгаа учраас бусад шинжилгээнүүдийг нь хийгээд, ТЭЗҮ шаардахгүйгээр бас зарим төрийн үйлчилгээний төслүүдийг бол түншлэлээр хэрэгжүүлж болох юм. Гэхдээ тэр төрийн үйлчилгээний төсөл нь өөрийнхөө хамрах хүрээ, хэр хэмжээ, онцлогоосоо хамаараад ТЭЗҮ бас зайлшгүй шаардахаар байх юм бол бүрэн шинжилгээний шатад бол ТЭЗҮ-ийг нь хийлгээд явах бүрэн боломжтой байгаа шүү гишүүн ээ.

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн тодруулъя.

А.Ганбаатар: Баясгалан даргын хариултаас болохоор нөгөө Эрдэнэс Монгол, Эрчис Монгол гэдэг шиг 2 ийм хэсэгт хуваачихсан юм байна. ТЭЗҮ шаардагдах, ТЭЗҮ шаардагдахгүй гээд.

ТЭЗҮ шаардагдахгүй нь болохоор төрийн үйлчилгээний хэсэгт байгаа юм байна. Тэгэхээр яг энэ дээр тийм жагсаалт гарах уу. Ийм ийм төрийн үйлчилгээний ажилд ТЭЗҮ шаардагдахгүй байна гэсэн хуулийн хавсралт юм уу, эсвэл журмын хавсралт маягаар.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулж хариулах юм уу. 3 номерын микрофон.

Т.Баясгалан: Тийм ер нь бол яг тийм тусгайлсан жагсаалт бол батлагдахгүй гишүүн ээ. Яг энэ хуулийн 15 дугаар зүйлд байгаа түншлэлийн гэрээнийхээ төрлөөс хамаараад төрийн үйлчилгээний 2-3 төрлөөр түншлэлээр хэрэгжүүлэх хуульчилж өгсөн энэ төслүүдийн хүрээнд л ТЭЗҮ гэхдээ жишээлбэл эрүүл мэндийн ч юм уу, ямар нэгэн байдлаар хог хаягдлын ч юм уу, ямар нэгэн байдлаар төрийн

үйлчилгээтэй холбоотой, боловсролын ч юм уу энэ үйлчилгээтэйгээ хамааралтайгаар ТЭЗҮ-ийг бол зарим төслүүд дээр нь бол шаардаад явна. Жижиг төслүүд дээр нь бол ТЭЗҮ шаардахгүй байх ийм үзэл баримтлалтай байгаа шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. 2026 оны улсын төсөв бол их ороо бусгаа нөхцөл батлагдлаа. Маш олон нийтийн анхаарлын төвөөс гадна Их Хурал дээр ч гэсэндээ бас ажлын хэсэг будилаантай их тийм хүнд нөхцөл батлагдлаа гэж харж байгаа. Тэгээд анх Засгийн газраас төсөв оруулж ирэхэд бол маш олон төрлийн хүлээлтүүд байсан. Тэгээд тэдгээр хүлээлтүүд дундаас ер нь бол явцын дунд бол багш нарын цалин нэмэгдлээ. Эмч нарын цалин дээр бас шийдлүүд гарлаа.

Нөгөө талаас ерөөсөө энэ хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн зүгээс байсан татварын ачааллыг бууруулах тухай асуудал огт хүлээлтэд нийцсэнгүй. Энэ асуудал дээр бол ямар ч тийм шинэ зүйл гарсангүй. Засгийн газрын зүгээс төсөв өргөн барихдаа нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлнэ. Хувь хүмүүсийн хувьд авч байгаа буцаан олголтыг нэмэгдүүлнэ гэсэн боловч явж явж тэгээд энэ дагах хууль дээр орж ирж байгаа дээр нөгөө муу буцаан олголтоо хүртэл 10 дугаар сарын 1 хүртэл хойшлуулаад, тэгээд НӨАТ-ын буцаан олголт ч үгүй боллоо.

Тэгэхээр энэ төсвөөс бол хүмүүс энэ татварын дарамт ачааллыг бууруулах тийм хүлээлтээ ерөөсөө огт авсангүй. Тэгэхээр ойрын хугацаанд хэрэв Засгийн газраас төсвийн тодотгол хийгээд, бусад зүйлүүдийг оруулж ирэх юм бол энэ татварын ачаалал, дарамтыг бууруулах чиглэлээр ажиллаасай гэж хүсэж байна. Гол хүлээлт чинь бол энд байгаа шүү. Энэ төр данхайгаад байгаа, төсөв данхайгаад байгаа гол асуудал чинь энэ татварын ачаалал дээр бас байгаад байна. Тэгэхээр энэ дээр энэ Засгийн газар шийдэмгий алхам, арга хэмжээ авах юм уу, үгүй юм уу гэдэг чинь бол бас маргаантай хэвээр л байгаад байна.

2 дугаарт нь бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд ийм нэг төсөв дагасан хууль тогтоомж хэлбэрээр нэмэлт, өөрчлөлт оруулаад яваад байх юм уу. Уг нь миний ойлгосноор бол Гантөмөр сайдыг Эдийн засаг, хөгжлийн сайдаар ажиллаж байхад энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг нэг мөр бас цогцоор нь өөрчилж, бас энэ хувийн хэвшилд бас эдийн засгийн оролцоог нь нэмэгдүүлэх тал дээр бас ийм дорвитой шинэчлэл реформын шинж чанартай хууль оруулж ирнэ гэж ийм бас хүлээлттэй байсан. Харамсалтай нь бас л нэг ийм төсөв дагасан хэлбэрээр ийм бага өөрчлөлтүүдийг оруулж ирж байна. Тэгэхээр энэ хууль чинь бас хаана явж байгаа юм бэ. Зүгээр ийм аргацаасан, цаг хугацааныхаа хувьд тулгамдсан, гал унтраасан асуудлыг шийдэх маягтайгаар энэ хуулийн өөрчлөлтөө хийгээд байх уу гэсэн асуудал байна.

Төгсгөлд нь энэ “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” гэдэг энэ тогтоолд би бол анхнаасаа маш шүүмжлэлтэй байсан. Энэ Эрдэнэс Тавантолгойтой холбоотой энэ нүүрсний хулгайн асуудал чинь ерөөсөө бүрмөсөн шийдвэрлэгдэж, иргэдийн хувьд нийгэмд ийм итгэлцэл үүсээгүй байгаа нөхцөлд давхар Засгийн газар бүр Улсын Их Хурлаас тогтоол хэлбэрээр эрх аваад, Эрдэнэс Тавантолгойн ашиглагдаагүй орд газар дээр өөрсдөө бие даасан

хэлбэрээр гэрээ байгуулах ийм эрхийг Их Хурлаар батлуулна гэдэг бол өрөөсгөл санагдаж байгаа. Тэгэхээр Их Хурлын гишүүдийг үүн дээр бол бас бүү шийдвэр гаргаач ээ. Энэ тогтоол бол ийм ач холбогдолгүй, шаардлагагүй тогтоол. Хэрэв Засгийн газар үнэхээр улс төрийн зориг гаргаад, тодорхой асуудлуудыг Эрдэнэс Тавантолгой дээр шийдье гэвэл өөрсдөө түүгээрээ шийдэж болох боломжтой байгаа.

Гэтэл заавал Их Хурлаас ийм эрх авч байгаа нь бол асуудалтай хэвээр байгаад байгаа. Дарга аа, 1 минутаа нэмээд авчихъя.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Жаргалан: 2 дугаарт энэ Эрдэнэс Тавантолгой дээр хийгдсэн гэрээнүүдийг миний хувьд бол өнгөрсөн хугацаанд удаа дараа шаардсаны улмаас Эрдэнэс Тавантолгой дээр хийгдсэн 586 гэрээний 581 нь бол одоо ил болчихоод байж байгаа. ЕТТ.mn сайт дээр бол энэ гэрээнүүд бол ил тавигдчихсан байж байгаа. Тэгэхээр иргэд, судлаач нар, сэтгүүлч нараас энэ гэрээнүүд дээр бас дүн шинжилгээ хийж, хамтарч ажиллахыг бол бас хүсэж байгаа.

Ойрын хугацаанд Засгийн газар төсвийн тодотгол оруулж ирэх юм бол саяын дурдсан асуудал дээр анхаарал хандуулахыг хүсье. Мөн энэ тогтоол дээр дурдагдсан байгаа үдийн цайны хөтөлбөрийг бас Засгийн газрын энэ 2026 оны төсвийн тодотголд ахиж оруулж ирэхийг бас хүсье. Яагаад вэ гэхээр 2027 оны төсөвт оруулж ир гэж тогтоол хэлбэрээр явуулсныг бас манай бүлгийн зарим гишүүд бас уламжлахыг хүссэн байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүн үг хэллээ. Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: 2026 оны төсөв дээр боловсрол, эрүүл мэндийн салбарыг онцолж бас цалин хөлс, орлогыг нь нэмэгдүүлж, үйлдвэрчний эвлэлтэйгээ энэ төсөв батлагдах мөчид бас хамтын гэрээ хэлэлцээр хийж, боловсролын жилийг бол онцолж боловсролын салбарт цалин хөлсийг нэмэгдүүлэх, мөн суурь салбар болсон эрүүл мэндийн салбарынхаа цалин хөлсийг төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангаас нэмэхээр бол шийдвэрлэсэнд таатай байгаа.

Гэхдээ энэ дагасан төсөл дотор бол бид нар 1 зүйлийг дутуу орхисон байгааг би одоо бас дахиж хэлье гэж бодож байна. Боловсролын салбар дотор багшаас өөр маш олон ажилтнууд байдаг. Цэцэрлэгээс авхуулаад өглөө хүүхдийг чинь тосож аваад, цэвэрлэгээ үйлчилгээг нь хариуцдаг, аюулгүй байдлыг нь хариуцдаг, түлш, халуун дулаан байлгахыг нь хариуцдаг гээд энэ олон ажилчдыг ингээд энэ дагасан тогтоол дээр зөвхөн багш гэдэг байдлаар тавьчихаж байгаа нь ялгаварлан гадуурхсан асуудал болчих вий дээ.

Тийм учраас Боловсролын сайд энэ баталсан төсөвтөө багтаагаад, магадгүй төсвийн тодотгол дээр бас энэ цөөхөн 900 мянган төгрөгийн цалин авдаг юм шүү дээ. Энэ хүмүүсийнхээ асуудлыг бас давхар тодорхой хэмжээнд нь нэмэх ийм орон зайг нь байлгаж өгөхгүй бол нэг салбарт ажиллаж байгаа 1 байшин дотор ажиллаж байгаа энэ хүмүүсийгээ бас орхичихсон. Эрүүл мэндийн хувьд бол ажилтан гэдэг нь бол адилхан орсон байна.

Тийм учраас энэ асуудлыг дагасан тогтоол дээр засаж оруулж өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг бас хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэбат гишүүн санал хэллээ.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн буюу эсрэг байр суурьтай 2 хүртэл гишүүн санал хэлэх бололцоотой. Саналаа өгсөн гишүүд байна уу. Мандхай гишүүн, Баасанжаргал гишүүн байна. Мэндбаярын Мандхай гишүүн нэрээ татаж байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу хураалгасан санал:

1.Төслийн 5 дахь заалтын “хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг” гэснийг “хэлцлийг” гэж өөрчлөх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалтдаа бэлдье. Санал хураалт. Санал хураалтад 85 гишүүнээс 55 гишүүн оролцож, 64,7 хувиар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслийн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.40 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг Төсвийн байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т “Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан байгаа. Санал хураалт явах гэж байна. Гишүүдийг танхимдаа урьж байна. Орж ирэхийг урьж байна. Санал хурааж авах гэж байгаа тул гишүүд танхимдаа орж ирээрэй. гишүүд. Суудлаа эзлээрэй. Санал хураалт явуулъя. санал хураалт явуулъя.

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүнээс 64 гишүүн оролцож, 74,4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүнээс 65 гишүүн оролцож, 75,6 хувиар санал дэмжигдлээ.

3.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүнээс 55 гишүүн оролцож, 64,4 хувиар санал дэмжигдсэнгүй. Тогтоолын төсөл дэмжигдлээ.

4.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 86 гишүүнээс 57 гишүүн оролцож, 66,3 хувиар санал дэмжигдлээ.

Хууль, тогтоолын төслүүдийг баталж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархлаа илэрхийлье.

10.49 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна. Үүрийнтуяа таныг индэрт урьж байна.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэн дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Засгийн газарт дараах асуудлаар зөвшөөрөл, чиглэл, үүрэг өгөхөөр тусгалаа. Үүнд:

1.Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.1} дэх хэсгийг үндэслэн Нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад буй асуудлуудын санхүүжилтийг

шийдвэрлэх зорилгоор нийслэлийн дотоод үнэт цаас гаргах асуудлыг холбогдох хууль, бодлогын баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх;

2.Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, ажилтнуудын ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын 2026 оны төсвийн хуулиар багш, эмч, эрүүл мэндийн ажилтан, эрдэм шинжилгээний байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа төсвийн байгууллагын үндсэн цалинг хуульд заасан хэмжээгээр нэмэгдүүлэх;

3.Төрийн албаны тогтолцоог шинэчлэн сайжруулж, хүний нөөцийн бодит үнэлэмж, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбар хооронд үүссэн цалин хөлсний тэгш бус байдлыг арилгах үүднээс төрийн албаны ангилал, зэрэглэлийг шинэчлэн, түүнтэй уялдуулан төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг оновчтой тогтоох эрх зүйн орчныг сайжруулах;

4.Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, хөрөнгийг үр ашигтай ашиглах, төслүүдийн хэрэгжилтийн сахилга хяналтыг сайжруулах үүднээс төсвийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн боловч дуусаагүй, зогссон барилга байгууламж, төслүүдэд дүн шинжилгээ хийх, холбогдох арга хэмжээг авах;

5.Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, хөгжлийг дэмжих, боловсролын орчныг сайжруулж, сургалтын чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын 6-12 дугаар ангийн нийт сурагчдад үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг судлан холбогдох эрх зүйн орчныг сайжруулж 2027 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авах;

6.Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн дээрх хуулийн төслүүдтэй харьцуулж, Үндэсний аудитын газрын дүгнэлт гаргуулж, 2025 оны 12 сарын 31-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд танилцуулах зэрэг саналыг төсөлд тусгалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. 3 гишүүн өглөө. 3 гишүүнээр тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ төсөв батлагдсантай холбогдуулж “Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2.1 дээр “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, насан туршийн боловсролын төвийн багш нарын” гэж байгаа юм. Ажилтнууд нь орхигдчихсон байна. Тэгэхээр ирэх жил он гарангуутаа нөгөө цалингийн нэмэгдлүүд нь ажилтнуудын, үйлчилгээний ажилтнуудын үйлчлэгч, сантехникч, цахилгаанчин, жижүүр, манаач энэ хүмүүсийн цалин мөнгөний асуудал нь орхигдож байна гэж ойлгохоор байна уу. Яахаар байна. Зөвхөн багш нар нь орж байгаа юм биш үү. Тэгэхээр энэ чинь бас салбарын нэг хэсэг хүмүүсийг орхигдуулаад, гээгдүүлээд явах гээд байна. Тийм учраас энэ багш гэсний араас ажилтны, ажилтнуудын гэдэг үгийг оруулах, ингэж байж боловсролын салбарын багш, ажилтнуудын цалин мөнгөний асуудал бүтэн цогцоороо шийдэгдэнэ. Тэгэхгүй бол энэ авах арга хэмжээний тогтоол дээр гээгдсэн байна. Энэ санамсаргүйгээр гээгдэв үү. Үнэхээр санаатайгаар гээчхэв үү. Энийг тодруулж хариулж өгөөч.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ тогтоолын төслийг бид бас урьдчилж хараад, санал онолоо явуулаад, ажилтны гэдэг үгийг оруулахаар ажиллаж үзсэн. Өнөөдөр бид нийт боловсролынхоо салбарт ажиллаж байгаа 93 мянган багш, ажилтны цалинг нэмэхэд 960 тэрбум төгрөгийн ийм нэмэгдэл цалингийн эх үүсвэр хэрэгтэй байсан. Гэвч энэ удаад бол 520 тэрбум нь шийдэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл энд эрдэм шинжилгээний ажилтнууд нь ороод. Тэгэхээр энэ дээр бол бид төсвийн хувьд нэлээн өндөр ийм савлалттай ийм эх үүсвэр болох юм байна гэсэн ийм тайлбарыг төсвийн ажлын хэсгээс бол хүлээж авсан. Бид өөрсдөө өнөөдөр батлагдсан хүрээндээ цалингийн бүтцээ өөрчлөх, мөн оновчтой бүтцийг бий болгох ийм хүрээндээ бас өөрсдөд олгогдсон төсвийн хүрээндээ бас ажилтнуудынхаа цалинг давхар бас бодолцож явах шаардлагатай гэж харж байгаа. Батлагдсан төсвийнхөө хүрээнд шүү. Мөн цаашдаа бас энэ төсвийг тодотгох шаардлага гарвал бас энэ эх үүсвэрийг дахиж хайх ийм шаардлагатай гэж үзэж байгаа.

Ер нь бол хууль дээрээ багш нарын гээд гарчихсан байгаа. Тэгээд энэ тогтоолоо харах юм бол яг батлагдсан төсөвтөө тааруулан хэмжээнд нь гэсэн ийм үг байгаа. Ийм учраас зүгээр яах вэ ажилтны гэдэг үгийг нэмчхээд, энэ дээрээ бас төсвийн хүрээнд өөрсдөө салбарын хүрээнд бас ярилцаад шийдээд явах боломж бас байна уу гэж харж байгаа юм. Зүгээр ажилтны гэдэг үгийг нэмчих бас боломж хэрвээ байвал бас энэ дээр оруулбал их зүгээр гэсэн ийм байр суурийг салбарын сайдын хувьд барьж байгаа. Ер нь бол оруулбал бас энэ угаасаа төсвийн хуулиараа ингээд гарчихсан байгаа учраас хэмжээнд нь тааруулаад энэ боломжтой гээд. Хажууд нь эмнэлгийн хувьд, анагаахынхны хувьд бол эмнэлгийн эмч, ажилтнуудын гэдэг үг нь бол байж байх жишээтэй ийм л нөхцөлд байгаа учраас энэ бас зүйтэй байна уу гээд. Тэгэхээр энэ дээр хэрвээ орох юм бол дэмжих нь зүйтэй гэж харж байна.

Би дахин хэлье. Бид батлагдсан төсвийнхөө хүрээнд бас энэ ажлыг уян хатнаар зохицуулах боломжийг эрэлхийлж байгаа. Боломжтой гэж харж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийн дарга Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Ажлын хэсгийн хүрээнд энэ асуудлыг ярилцсан. Ярилцаагүй биш яригдсан. Төсвийн ажлын хэсгээс орж ирсэн тооцоо, судалгаанд үндэслэж төсвийн ажлын хэсгийн оруулж ирсэн саналын дагуу бид энэ хууль тогтоомжийн төслүүд дээр ажиллаж байгаа. Зөвхөн 1 үгийн тухай асуудал биш л дээ Наранбаяр сайд аа. Энэ үгийн ард 400 тэрбум төгрөгийн асуудал яригдаж байгаа юм. Яагаад гэхээр Төсвийн хууль дээр та сая хэллээ. 520 тэрбум төгрөгөөр цалингийн асуудал нэмэгдсэн. Энэ бол багш нарынхаар тооцож, Боловсролын яам, Сангийн яам, ажлын хэсэг дээрээ хамтдаа тооцооллоо хийж, багш нарын цалингийн өсөлтөөр тооцож, төсөвт оруулж батлуулсан дүн. Энэ дээр ажилчид гэдэг үгийг ажлын хэсгийн хувьд дэмжээд гэдэг юм уу оруулчихад 400 тэрбум төгрөгийг хаана гаргах вэ гэдэг асуудал үүснэ.

Өчигдөр Боловсролын яамны бас холбогдох санхүүгийн хэлтсийн дарга ирж уулзсан. Энэ асуудал дээр .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүн гүйцээж хариулъя.

Д.Үүрийнтуяа: Энэ асуудал дээр төсвийн тодотгол орох үеэр зохицуулаад хийе. Батлагдсан төсөвтөө эхний хагас жилдээ багш, ажилчдаа нэмье гэдэг зүйлийг ярьж байна лээ. Тэгэхээр одоо тодотголын асуудал төсөв батлагдаж байхад, дараагийн тодотголын асуудлыг төлөвлөж ийм байдлаар тогтоолд оруулах нь боломжгүй байгаа юм. Тийм учраас Боловсролын яам өөрөө энийг зохицуулалт хийх боломжтой бол тэрийгээ засгийнхаа түвшинд дотооддоо хийх нь зүйтэй.

Нэгэнт батлагдсан төсөвтэй уялдуулж гарч байгаа тогтоолын хувьд энэ үг, үсгийг нэмэх нь эдийн засгийн хувьд бол томоохон үр дагавар авчрах ийм эрсдэлтэй байгаа гэдгийг бас манай гишүүд ойлгох хэрэгтэй гэдгийг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Үүрийнтуяа гишүүн ээ, ойлгож байгаа. Та бас ажлын хэсгээ яг ажлыг нь бас ингээд зохицуулаад, энд асуудлаа хамгаалж байгааг ойлгож байгаа. Гэхдээ боловсролын салбарт байж байгаа 93 мянган хүний цалингийн асуудал яригдаж байна. Зөвхөн багш нарыг гэж ялгах нь бас их хэцүү. Тийм учраас хэмжээнд нь тааруулаад, өнөөдөр батлагдсан энэ хэмжээнд нь тааруулаад бид нар уян хатан зохицуулалтаа хийгээд, цалингийн бүтцээ яриад явах боломжтой гэж харж байна.

Өнөөдөр бол тодотголыг хэлэх хэцүү. Тодотгол хэрвээ хийгдэж байгаа тохиолдолд бид тодотголоор бол энэ асуудлыг оруулж ирнэ. Ийм учраас яах вэ, энэ дээр нэгэнт төсвийн хууль нь гарчихсан хуульдаа бариад, хэмжээнд нь тааруулаад гэсэн үг нь байж байгаа учраас зүгээр ажилтны гэдэг үгийг нь яг эрүүл мэндийнхэн шиг оруулчихад бол болохгүй гэх газар байхгүй л дээ. Энэ төсөв дээр бол шууд дарамт болж орж ирнэ гэж харахгүй байгаа шүү. Тэгэхээрээ та бас энэ дээр боловсролын салбарын онцлог байдлыг ойлгох хэрэгтэй. Та чинь өөрөө бас энэ

чиглэлийг сайн мэддэг хүн. Ийм учраас би зүгээр энэ асуудлыг зүгээр оруулчих, бид энэ хуулийнхаа хэмжээнд л энийг шийдвэрлэе гэж ярьж байна шүү дээ. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ, та нар тэгээд сая ажил хаяхад тэгээд боловсролын салбарынхан нийтээрээ ажил хаясан шүү дээ. Зөвхөн багш нар нь ажил хаяад, багш нарынх нь цалинг 1 сарын 1-ээс нэмэх гэж байгаа юм уу. Тэгээд үйлчилгээний ажилтнуудыг нь орхих гэж байгаа юм уу. Тэгээд дотоод цалингийнхаа төсөвтөө багтааж нэм гэж тийм төсөвтөө багтааж нэмэх сургуулийн байгууллагуудын төсөв тийм хүрэлцээтэй төсөв байхгүй байгаа. Тэгээд та нар энийгээ ажлын хэсэг дээр Сангийн яам, Засгийн газар яаж ингэж худлаа багш нар, боловсролын салбарынхныг ингэж худлаа ярьж оруулж ирж байгаа юм бэ. Одоо бүгд 1 сарын 1-ээс цалингаа нэмүүлнэ. 50 хувиар нэмэгдүүлнэ гэсэн ойлголттой байгаа шүү дээ. Бид нар ч гэсэн тийм ойлголттой байсан шүү дээ. Гэтэл одоо энэ дагаж байгаа тогтоолоор бол зөвхөн багш нарынх 50 хувь нэмэгдээд, салбарын ажилтнуудын цалин бол нэмэгдэхгүйгээр орж ирж байна шүү дээ. Тэгээд худлаа дундаа ингээд 2 бие рүүгээ яриад, дунд нь ингээд асуудал, энийгээ тодорхой шийд л дээ.

Ж.Бат-Эрдэнэ: Үүрийнтуяа гишүүн. Энийг сайн тодруулж өгөөрэй.

Д.Үүрийнтуяа: Үгүй ээ, Наранбаяр сайд аа. Одоо тэгээд нөгөө ажилчдын цалин нэмээгүй нь миний буруу юм шиг юм яриад суугаад байх юм. Үгүй ээ, энэ чинь салбарын яам таны ажил шүү дээ. Та энэ тооцооллоо хийгээд, төсвийн ажлын хэсэгтэйгээ, Сангийн яамтайгаа оруулаад тооцооллоо бодитой гаргаад, энийгээ төсөвтөө суулгаагүй байж байж одоо ийм асуудал над руу яриад байдаг нь ямар учиртай юм бэ. Энэ чинь таны ажил. Уучлаарай. Та бүхний тохироод төсөвтөө суулгачихсан дүнд чинь тааруулж, тогтоолын төсөл боловсруулж байгаа юм.

Өөрөөр хэлбэл та нарын хоорондоо тохироод Сангийн сайд, Боловсролын сайд, ажлын хэсэг дээр асуудлаа яриад оруулаад ирсэн төсөвт багтсан дүнгээр тогтоолын төсөл орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээрээ одоо тогтоолын төсөл хэлэлцээд явж байхад ч гэсэн ажлын хэсэг дээр тэр зарчмын зөрүүтэй саналаа оруулаад, ажиллаад явах чинь таны үүрэг байхгүй юу. Тэгээд одоо чуулганы танхимд ийм юм яриад сууж байж та болохгүй шүү дээ. Хариуцлагатай байх хэрэгтэй шүү дээ салбарын сайд юм бол.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ ажлын хэсэг дээрээ юу ярьцгаасан юм бэ та нар. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Энэ “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” гээд энэ Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг би өнөөдөр сая л харж байна. Тэгээд энэ Төсвийн байнгын хороо дээр хэлэлцсэн бололтой юм байна. Түүгээрээ яригдсан бололтой юм байна. Тэгэхдээ шууд анхны хэлэлцүүлэгт ингээд оруулаад ирж байгаа явдал бол бас болохгүй. Уг нь бид гишүүддээ аль болох мэдээлэл өгч байж, танилцах боломжоор хангая гэж жил тойрон л ярьж байна. Гэтэл дахиад л ингээд байх юм.

Тэгээд энэ дээр хэд хэдэн ноцтой асуудлууд бол байна.

1.1.Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод тулгамдаад буй асуудлуудын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор 275 тэрбум төгрөг хүртэлх нийслэлийн дотоодын үнэт цаас гаргана гэнэ. Улаанбаатар хот, нийслэл бол сүүлийн 2 жил мөнгөөр туйлж байгаа. Сүүлдээ бүр хэдэн их наядаар зам барина. 1км замыг хэчнээн тэрбумаар барина гээд сууж байгаа газар. одоо сүүлдээ болохоор бүр урд хөршөөс Хятад улсаас хагас коксжих түлш 200 гаруй тэрбум төгрөгөөр импортлоод сууж байгаа ийм газар. Тэгэхэд одоо нийслэл дээр ахиж ийм бонд гаргаад, 275 тэрбум төгрөгийн бонд гаргаад сууж байх хэрэг байдаг юм уу. Энэ хаанаас бас яагаад ороод ирчихсэн юм бэ.

Өмнөх тэр гаргасан бондынх нь зарцуулалт нь бас тодорхойгүй баахан зам зассан гэдэг. Хувийн хэвшилд тэр Бөөрөлжүүтийн цахилгаан станцад 300 тэрбумыг олгосон гэдэг. Тэгээд энэ Улаанбаатар хот чинь ерөөсөө мөнгөөр туйлаад, юу болж байгаа нь мэдэхгүй, дандаа л их наяд, тэрбумаар яригддаг болчихсон ийм газар дээр дахиад 275 тэрбум төгрөгийн бонд гаргана гэдэг нь яг ямар учиртай юм бэ. Тэгээд энд хэн хариулах юм бэ. Нийслэлээс 1 ч хүн алга. Сангийн сайд нь алга. Эдийн засаг, хөгжлийн сайд нь алга. Ерөнхий сайд нь бүр алга. Тэгээд ийм асуудал орж ирж байхад тэгээд бид нар зүгээр энийг нь кноподоод сууж байх уу.

2.2.Төрийн албаны ангилал, зэрэглэлийг шинэчлэн, түүнтэй уялдуулан төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийн асуудлыг оновчтой тогтоох эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох хуулийн төслийг оруулж ир гэнэ. Анх энэ 2026 оны жилийн төлөвлөгөө батлагдаж байхад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах асуудлыг бол Гантөмөр сайд бас оруулж ирж, батлуулж байсан. Тэгээд яг энэ төрийн албан хаагчдын тоо бодитоор энэ сая батлагдсан төсөвт яг хэдэн хувиар буурч орж ирж байгаа талаар бас хэн мэдээлэл өгөх вэ. Мэдээлэл авмаар байх юм.

Тэгээд цаашлаад энэ тогтоол дээр танилцуулагдсан асуудал дээр бас төрийн албан хаагчдын тоог цөөлөх тал дээр бас зүйл заалт оруулмаар байх юм. Түүнээс биш цалин хөлсийг нь нэмэгдүүлнэ л гээд байдаг. Дараа нь бид нар урсгал зардлаа ерөөсөө огт дийлэхээ байгаад, өнөөгийн нөхцөл байдалд ирчхээд байж байгаа шүү дээ. Тэгэхээр ахиад л энэ тоог нь ярихгүй зөвхөн нэмэгдлийг нь ярина гэдэг бол оновчтой бус санагдаж байна.

Тэгээд хурлын дарга аа, энд ба сайд нар ч байхгүй. Ер нь асуултад хариулах ч хүн байхгүй байгаа нөхцөлд бид нар энийг хэлэлцээд сууж байх шаардлага байгаа юм уу, үгүй юм уу. Нийслэлийн асуудал дээр та хариулт өгөх юм уу. Нийслэлийн асуудал дээр хэн хариулт өгөх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Төсвийн байнгын хорооноос ажлын хэсгээс оруулж ирж байгаа шүү дээ. Ажлын хэсгийн ахлагч Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: Энэ тогтоол бол Төсвийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төсөл орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн хуулийг хэрэгжүүлэх үүрэг, чиглэлийг Засгийн газарт Их Хурлаас өгч байгаа тогтоолын төсөл юм.

Жаргалан гишүүний хэлж байгаа тэр нийслэлийн бондтой холбоотой, үнэт цаас гаргахтай холбоотой асуудал 275 тэрбум төгрөг орж ирсэн. Бид дагасан хууль тогтоол дээр “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг түрүүн дэмжээд, баталсан. Яг энэ дотор багтаж байгаа гэсэн үг.

Энэ дотроос салгаад нийслэлийг яагаад тусад нь дахиад тогтоолын төсөлд дүн заагаад ороод ирэв гэж. Засгийн газраас өргөн барьсан Нийслэл үнэт цаас гаргахаар тооцсон байсан заалт дээр Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргаад, энэ дүнг 425 тэрбум төгрөг болгож өөрчилсөн, нэмэгдүүлсэн. Үүнтэй холбоотой аймгийн болоод нийслэлийн гаргах үнэт цаасны хэмжээг нь ялгаж, нийслэлийг тусад нь оруулж өгч байгаа. Үлдсэн нь аймаг дээр гарна гэсэн үг. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид энийг өмнөх тогтоолоороо 1 дүгээрт эрхийг нь олгочихсон. 2 дугаарт төсөв дээрээ дүнгээ баталчихсан. Одоо энэ тогтоол дээр бол нийслэл, аймгаар нь ялгаж өгч байгаа зааг оруулсан заалт гэж 1 дүгээрт ойлгох хэрэгтэй. Яагаад гаргаж байгаа, нийслэл шаардлагатай эсэх талаар бас Засгийн газрын зүгээс хариулах нь зүйтэй байх гэж бодож байна.

Төрийн албаны ангилал зэрэглэлтэй холбоотой энэ заалт энэ удаагийн төсөв дээр багш нар, эмч нар, төрийн албан хаагчдаас энэ 2 салбарын ажилчид бас ажил хаялт зарлаж, жагсаал хийж, тодорхой хэмжээгээр цалин хөлсний өөрчлөлтүүд орж ирсэн. Цаашдаа бид нар аль нэг асуудлаар юу гэдэг юм цалингаа нэмэгдүүлье гэж жагссан салбарын цалинг нэмдэг биш, төрийн албан хаагчдын цалингийн өсөлт, цалингийн нэмэгдэл нь тухайн албан хаагчдынхаа бүтээмжтэй, хөдөлмөрийн үнэлэмжтэй уялддаг байх ёстой юм. Бодлоготой байх ёстой юм. Энэ цалингийн асуудлыг зөвхөн 1 салбарыг ялгаж авч нэмснээр төрийн албан хаагчдын цалингийн шатлал, ангилал, зэрэглэл дотор хэт их зөрүү үүсчих ийм эрсдэлээс сэргийлэх үүднээс эндээ Засгийн газар үнэлгээ, дүгнэлт, судалгаа хийж, нэгмөсөн энэ цалин хөлснийхөө тогтолцоо, бодлогыг шинэчил гэдэг ийм үүрэг даалгавар өгч байгаа юм.

Өөрөөр хэлбэл ирэх оны төсөв хэлэлцэх үеэр дахиад аль нэг салбар жагсаад ороод ирэх биш, цалин хөлсний бодлого нь Засгийн газраас тогтвортой, урт хугацаанд, бүтээмжид суурилсан ийм бодлогоо оруулж ирээрэй гэдэг үүрэг даалгаврыг энэ заалтаар өгч байгаа гэж та ойлгох хэрэгтэй шүү.

Ж.Бат-Эрдэнэ: Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Хэрэв нийслэл, аймгаар нь ялгаж байгаа бол тэр нөгөө аймаг гэж дурдсан нь бас хаана байгаа юм Тэгээд ер нь бол Улаанбаатар хот дээр маш их хэмжээний хөрөнгө оруулалтууд, зарцуулалтууд хийгдэж байгаа. Тэгээд энэ дээр бол хотын удирдлага бас орж ирээд тайлбараа хийх нь зөв гэж харж байгаа.

2 дугаарт нь тэр төрийн албаны ангилал, зэрэглэлтэй холбоотой асуудал дээр бол бид нар нэгэнт цалин хөлсний нэмэгдлийг оновчтой болгох гэж байгаа гэж үзэж байгаа бол миний яриад байгаа зүйл бас орон тооны асуудал давхар заавал дурдагдах ёстой шүү гэдэг зүйлийг яриад байгаа юм. Орон тоо нь оновчтой, үр ашигтай байж байж бас энэ цалин хөлс, бүтээмжтэйгээ уялдана гэсэн ийм агуулга.

Тэгэхээр энэ дээр бол бас зарчмын зөрүүтэй санал оруулж, батлуулъя гэсэн бодолтой байна. Бас дахиад нэг асуудал. Манай Ардчилсан намаас сонгогдсон Сэддорж гишүүн.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Жавхлан гишүүн хариулах уу. Түрүүний асуудал дээр бас тодруулах гээд байсан. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Жаргалан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Засгийн газраас өргөн барьсан Төсвийн тухай хуулийн төсөл дээр энэ нийслэлийн бонд бол

байгаагүй шүү. Ажлын хэсэг дээрээс гаргасан санал ч биш юм байна лээ. Нэр бүхий гишүүд хэлэлцүүлгийн явцад гаргасан санал юм байна лээ. Тэгээд 150 буюу Өмнөговь дээр байсан дотоодын бонд дээр 275 тэрбум төгрөгөөр нийслэлээс нэмж гаргая. Эрх авъя гэдэг ийм саналын томъёолол ороод дэмжигдсэн юм байна лээ.

Тэгээд төсөв дээр энэ тоо нь орчихоор, дагасан тогтоолоор энийг дахиж баталгаажуулдаг өөрөө ийм журамтай. Тийм учраас энэ тогтоол дээрээ нэмж орж ирсэн юм байна гэж ингэж ойлгож байгаа.

Тэр Засгийн газраас өргөн барьсан дээрээ бол орон нутгийнх нь буюу тэр Өмнөговь аймгийнх байж байгаа учраас тогтоол дээр нэмж орох шаардлага байхгүй гэж харж байгаа юм. Ийм процесс болж байгаа. Тийм учраас та уг нь яг тэр саналын томъёолол нь яваад, Байнгын хороо дээр хэлэлцэж байхад нь уг нь ороод энэ үгээ хэлсэн бол уг нь нэг зүгээр байж дээ. Одоо ч/минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Би түрүүн бас хэлсэн. Тэгээд Их Хурал гаргаж байгаа энэ тогтоол бол ямар нэгэн байдлаар маргаангүй, нэг мөр ойлгогдох ёстой. Төсөв бол батлагдсан. Төсвийн хууль бол батлагдсан. Төсөв дотроо багтаагаад зохицуулаад явах эрхийг нь Засгийн газарт нь өгье л дөө. Тэгэхгүйгээр заавал багшийг нь л нэм гэсэн. Бусад ажилчид гэдэг үгийг нь Их Хурлын тогтоол дотор алга гэдэг ийм маргаан үүсгээд явчихвал энэ чинь Засгийн газрыг цааш нь ажил хийх боломжоор нь хангахгүй хаачих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энийг тэртэй тэргүй Засгийн газар төсвөө батлаад, тэр яаж зохицуулдаг байна вэ, тэр дараа нь нэмэлт эх үүсвэр, өөр хэмнэгдсэн юугаа дотор нь зохицуулдаг байна уу, энийг нь Засгийн газарт ажиллах боломжийг нь өгөөд, ингээд зохицуулаад явъя л гэдэг ийм саналыг л би хэлээд байгаа юм.

Түүнээс биш төсөв бол тодорхой хэмжээний эх үүсвэрийн дутагдалтай батлагдсан нь үнэн. Тийм учраас боловсролын салбар байна, бусад салбарууд байна. Тэр төсвийн ажилтнуудыг хэмнэх 4, 5 мянган ажилтны орон тоо дутуу байгаа. Тэр хэмнэсэн төсвөө тэр үйлчилгээнийхээ тэр шүүр бариад сууж байгаа, хүүхэд манаад сууж байгаа хүмүүстээ өгнө үү, байна уу гэдэг асуудал нь Засгийн газар өөрөө кабинетынхаа зарчмаараа асуудлаа яриад шийдэх эрхийг нь л өгье. Тэгэхгүй бол ингээд орчих юм бол Улсын Их Хурлын тогтоол дээр үйлчилгээний ажилчид гэдэг нэр томъёо байхгүй учраас бид нар нэмж болохгүй гэдэг л ийм юм руу Засгийн газрынхаа ажиллах юмыг нь хааж өгөх юмыг Их Хурал заавал хийх хэрэг байгаа юм уу. Заавал 1, 1 хүнийх нь нөгөө нэрээр нь оруулах хэрэг байгаа юм уу. Багш, эмч, слесарь, үйлчлэгч гэж оруулах юм уу. Яах юм энэ чинь. Тийм учраас би энэ тогтоол дээр нийт утгаар нь оруулаад л боловсрол эрүүл мэндийнхээ салбарын ажилтнуудын цалинг тэр төсөв юундаа багтаагаад шийд гэдэг ийм утгаар л оруулчихвал тэгээд маргаан байхгүй болчих юм биш үү л гэж би бодож байна.

Ж.Бат-Эрдэнэ: Төсөв батлагдсан. Төсвийнхөө хүрээнд ажлаа хийгээд явах нь дээр байх гэж бодож байна. Наранбаяр сайд тодруулчихъя.

П.Наранбаяр: Баярлалаа энэ бас зүйтэй санал. Эрдэнэбат гишүүн хэлээд байгаа бол маш зүйтэй. Бид бас өнөөдөр батлагдсан төсвийнхөө хүрээнд л энэ асуудлуудаа өөрсдөө чадах хэмжээндээ шийдээд явах боломж бас байгаа юм. Ийм учраас энэ тогтоолын төсөл дээр ажилтны гэдэг үгийг оруулаад өгөх нь бол бас

зүйтэй гэж харж байгаа. Энэ дээр бид бас энэ чинь төсөв нэгэнт батлагдсан. Тэр хэмжээнд нь тааруулан гэсэн үг байж байгаа. Тэгээд энэ тал дээр бас төсвийн энэ ажлын хэсэг ч гэсэн бид бүхий л өөрсдийнхөө боломжтой бүхий л шугамаар ярьсан. Саналаа хэлсэн. Бүгдийг нь хийх гэж оролдсон. Сангийн яамтайгаа ч зөвшилцөж, ярилцсан. Хүндрэлтэй байгааг ойлгож байна. Гэхдээ энэ үгийг оруулснаараа бид өнөөдрийн энэ байгаа төсвөө задлах юм юу ч биш. Төсвийн тухай хуульд чинь энэ чинь орчихсон байгаа. Эндээ тааруулна гэсэн үг чинь явж байгаа. Ийм учраас энэ ажилтны гэдэг үгийг оруулах нь зүйтэй байна. Засгийн газарт ажиллах боломжийг нь бас олгох нь зүйтэй байна гэсэн ийм л зүйлийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Наадхаа ажлын хэсэг дээр оруулах байсан шүү дээ. Одоо бол дахиж засаж оруулна гэсэн ойлголт ерөөсөө байхгүй.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 90 гишүүнээс 33 гишүүн дэмжиж, 36,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

11.21 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж, ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль, тогтоолын эцсийн найруулгыг Төсвийн байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байвал саналаа хэлье. Алга байна. эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Нэрээ өгөөрэй. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: 2026 оны төсөв бол маш их алдаа, дутагдалтай төсөв болсон. Маш олон хуулиудыг зөрчсөн. Сая хүртэл зөвхөн багшийн цалинг нь нэмэгдүүлсэн байна. Боловсролын салбарт ажиллаж байгаа ажиллагсдынх нь үйлчилгээний ажилтны цалин нэмэгдээгүй байна гэдэг маргаан үүслээ. Үнэн. Зөвхөн багш нарын цалинг нь нэмэгдүүлсэн болохоос биш боловсролын байгууллагад ажиллаж байгаа ажиллагсдын цалин хөлсийг бол орхигдуулсан. Ийм учраас уг нь бол миний зүгээс энэ төсвийг уг нь баталмааргүй байгаа юм. Эсвэл хориг орж ирмээр байгаа юм.

Тэгээд үүнгүйгээр явчих юм бол хүчээр тэгээд батлагдаад, ёсчлоод явах юм бол яаралтай төсвийн тодотголоо эргүүлэн оруулж ирж, энэхүү алдаа дутагдлуудаа зас. Хуурсан, мэхэлсэн, зохистой байдлыг алдагдуулсан, төрийн албан хаагчдыг ялгаварласан ийм төсөв болсон шүү гэдгийг зайлшгүй хэлэхээс өөр гарцаагүй.

Тэгээд бусдаар батлаад явах юм бол хориг орж ирэх үү, үгүй юу гэдгийг харъя. Эс бөгөөс тэгээд яаралтай энэ төсвийн тодотголоо оруулж ирээ. Эмч нарын ч гэсэн хэлэлцээрийг дөнгөж өчигдөр байгуулсан. Энэ амлалтдаа бол ямар нэгэн байдлаар төсвийн санхүүжилтээр баталгаажуулаагүй байгаа. Тэгэхээр энэ дээр бол гарцаагүй дахиад төсвийн асуудал бол орж ирнэ гэдгийг зайлшгүй хэлэхээс өөр арга алга.

Ж.Бат-Эрдэнэ: Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Сонссонд тооцлоо.

11.25 цаг.

Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

11.25 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ